



НИЙСЛЭЛИЙН БАГАХАНГАЙ ДҮҮРГИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2022 оны 12 сарын 01 өдөр

Дугаар

А/244

Улаанбаатар хот

Дүүргийн аварга шалгаруулах шатрын Тэмцээн зохион байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Төсвийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.2.2, Сангийн сайдын 2021 оны 61 дүгээр тушаалын хавсралтын 2.1.5 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. “Монгол Улсын Үндсэн хуулийн өдөр”-ийг угтан дүүргийн аварга шалгаруулах шатрын тэмцээнийг 2022 оны 12 дугаар сарын 03-ны өдөр зохион байгуулсугай.
2. Тэмцээнийг халдвар хамгааллын дэглэм, хүн хоорондын зайг баримтлан зохион байгуулахыг Биеийн тамир, спортын хороо (Г.Тэмүүлэн)-нд үүрэг болгосугай.
3. Тэмцээн зохион байгуулах удирдамжийг нэгдүгээр, зарцуулагдах хөрөнгийн төсвийг хоёрдугаар хавсралтаар баталсугай.
4. Арга хэмжээнд зарцуулагдах 480.000 (Дөрвөн зуун наян мянган) төгрөгийг Засаг даргын нөөц хөрөнгөөс гаргахыг Засаг даргын Тамгын газрын Ерөнхий нягтлан бодогч (С.Баасанхүү)-д зөвшөөрсүгэй.
5. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж үр дүнг тооцон ажиллахыг Засаг даргын Эдийн засаг, нийгмийн хөгжлийн асуудал хариуцсан орлогч (Б.Болормаа)-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



А.СҮХБОЛД

AJIL/2022 он ажил/захирамж

1123200775

Нийслэлийн Багахангай дүүргийн Засаг даргын
2022 оны 12 дугаар сарын 01-ны өдрийн
12 дугаар захирамжийн хавсралт

БАГАХАНГАЙ ДҮҮРГИЙН АВАРГА ШАЛГАРУУЛАХ ШАТРЫН ТЭМЦЭЭНИЙ УДИРДАМЖ

НЭГ. ЗОРИЛГО

“Монгол Улсын Үндсэн хууль батлагдсан өдөр”-ийг тохиолдуулан шатрын спортыг хөгжүүлэх, түгээн дэлгэрүүлэх, иргэд олон нийтийн чөлөөт цагийг зөв боловсон өнгөрүүлэх, оюуны спортыг таниулахад тэмцээний зорилго оршино.

ХОЁР. ЗОХИОН БАЙГУУЛАГДАХ БАЙГУУЛЛАГА ХУГАЦАА

2022 оны 12 дугаар сарын 03-ны өдрийн 11.00 цагт дүүргийн Биеийн тамир, спортын хорооны зааланд зохион байгуулагдана.

Тэмцээнийг зохион байгуулах байгууллага:

- Дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурал
- Засаг даргын Тамгын газар
- Биеийн тамир, спортын хороо

ГУРАВ . ТЭМЦЭЭНИЙ ЯВАГДАХ ЖУРАМ

Тэмцээнд оролцох тамирчдын тооноос хамааран Техникийн зөвлөгөөн дээр сонгогдсон шүүгч тэмцээний журмыг танилцуулна.

Цагийн хяналт: талдаа 60 минут байна.

ДӨРӨВ: ТЭМЦЭЭНИЙ БҮРТГЭЛ

2022 оны 12 дугаар сарын 02-ны өдрийн 09.00-16.00 цагийн хооронд Биеийн тамир, спортын хороонд бүртгэнэ.

ТАВ: ОРОЛЦОГЧДОД ТАВИГДАХ ШААРДЛАГА

- Тэмцээнд 18-аас дээш насны /эрэгтэй, эмэгтэй/ дүүргийн иргэн оролцоно.
- Шатрын спортын цолтой иргэн оролцохгүй.
- Халдвар хамгааллын дэглэмийг баримтлах. /Амны хаалт зүүх, хүн хоорондын зай барих/ .

ЗУРГАА. ШАГНАЛ УРАМШУУЛАЛ

Эрэгтэй, эмэгтэй тус бүр

1-р байр Өргөмжлөл, Медаль, Мөнгөн шагнал

2-р байр Өргөмжлөл, Медаль, Мөнгөн шагнал

3-р байр Өргөмжлөл, Медаль, Мөнгөн шагнал

Нийслэлийн Багахангай дүүргийн Засаг даргын
2022 оны...~~12~~ дугаар сарын...~~2~~/ны өдрийн
~~А/244~~ дугаар захирамжийн хавсралт

БАГАХАНГАЙ ДҮҮРГИЙН АВАРГА ШАЛГАРУУЛАХ
ШАТРЫН ТЭМЦЭЭН ЗОХИОН БАЙГУУЛАХАД
ШААРДАГДАХ ХӨРӨНГИЙН ТӨСӨВ

Д/д	Шагнал	Хэмжих нэгж	Тоо ширхэг	Нэгж үнэ	Бүгд үнэ
Мөнгөн шагнал					
1	1-р байр	ш	2	100,000	200 000
	2-р байр	ш	2	80,000	160 000
	3-р байр	ш	2	60.000	120 000
	Нийт үнэ:				480 000